



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

┌ Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15,787,457 /арван таван сая долоон зуун наян долоон мянга дөрвөн зуун тавин долоо/ ширхэг энгийн хувьцааг 10 хувааж нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 157,874,570 /нэг зуун тавин долоон сая найман зуун далан дөрвөн мянга таван зуун дал/ ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН